

ОХИН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Д.Нямаа*

Хураангуй: Групп компанийн зохион байгуулалт нь үйл ажиллагааны төрөлжилт, хөрөнгийг удирдах хэлбэр, бизнесийг хөтлөн явуулах арга зарчим, охин компаниудын үйл ажиллагаанд тавих хяналтын түвшин, шийдвэр гаргалтын төв, өмчийн бүтэц гэх зэргээс хамаарах ба группын бүрэлдэхүүн дэх компаниудын бүтцийг оновчтой тогтоон, толгой компани нь охин компаниудын үйл ажиллагааг үр ашигтайгаар удирдан зохион байгуулснаар синергетик үр өгөөжийг ихээр хүртэх боломжтой болдог юм. Энэ өгүүлэлд группын бүрэлдэхүүн дэх охин компаниудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх арга зүйн асуудлыг авч үзэн “ХХХ” групп компанийн бүрэлдэхүүний охин компаниудын өнөөгийн байдлыг үнэлж, санал дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Түлхүүр үгс: Групп, охин компанийн үр ашгийн үзүүлэлт, интеграцлал, өнөөгийн байдлын үнэлгээ.

Abstracts: The group's organizational structure depends on specification of operations, forms of asset management, business activity principles, control level on subsidiaries, decision making center and equity structure and it is available to get more synergetic results through the formation of optimum structure of participants of holding. In this article are considered methodological issues and conclusions of the assessment of current position and efficiency of subsidiaries activity in group companies used in practice of one of the Mongolian holding company “ХХХ”.

Keywords: Holding, indicators of efficiency of subsidiaries, integration, assessment of current positon

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail) anu.nyam@yahoo.com

Группын бүрэлдэхүүн дэх охин ба хараат компаниуд үйлдвэрлэлийн харилцан хамааралд байх буюу технологийн гинжээр холбогдсон группийг интеграцлагдсан групп буюу босоо чиглэлтэй групп гэж нэрлэдэг. Тухайлбал, нефтийн салбарын томоохон группд толгой компанийн удирдлага дор олборлох, тээвэрлэх, боловсруулах, бүтээгдэхүүнээ борлуулах аж ахуйн нэгжүүд нэгдсэн байж болно. Группын өөр нэг төрөл бол конгломерат буюу худалдааны, зар сурталчилгааны, үйлдвэрлэлийн зэрэг технологийн хувьд холбоогүй аж ахуйн нэгжүүдээс бүрдсэн групп юм. Ийм төрлийн группын бүрэлдэхүүн дэх охин компаниуд нь аж ахуйн үйл ажиллагааны хувьд харилцан хамааралгүй байдаг.

Группын төрлөөс үл хамааран дээрх аж ахуйн нэгжүүдэд төвлөрсөн хяналтаас гадна төвлөрсөн бус хяналтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм. Учир нь хяналтыг хэт төвлөрүүлснээр дээд түвшний удирдлага урт хугацааны төлөвлөлт, шийдвэр гаргалтад анхаарлаа хандуулах боломжгүй болох, мөн бусад түвшний удирдлагын эрх мэдэл, бие даасан байдал хумигдах, тэдний шинийг эрэлхийлэлт, ажлын идэвх санаачлага буурдаг. Ялангуяа бизнесийн цар хүрээ томрох тусам дээд түвшний удирдлагын шийдвэр гаргалт, төлөвлөлт, удирдан зохион байгуулалт, хяналтын үйл ажиллагааны хүрээ хэт ихсэж, түвэгтэй болдог тул бусад түвшний удирдлага, менежерүүдэд харьцангуй бие даасан эрх мэдэл өгч, үүрэг хариуцлагыг хуваарилан төвлөрлийг саармагжуулах шаардлагатай болдог². Групп компанид төвлөрсөн бус хяналтыг хэрэгжүүлэхдээ дээд түвшний удирдлага аль салбар-охин компани, хөрөнгө оруулалтын төвийн үйл ажиллагаа үр дүнтэй, ашигт ажиллагаа сайтай байгааг үнэлж охин компанийн удирдлагад хяналт тавих, тэрчлэн хөрөнгө оруулалтын нэмэлт эх үүсвэрийг алинд нь оруулбал илүү оновчтойг үнэлж шийдвэр гаргах нь зүйтэй юм. Группын бүрэлдэхүүн дэх компаниудын бүтцийг оновчтой болгох дээрх зорилгын үүднээс толгой компани нь охин компаниудынхаа үйл ажиллагаанд дараах чиглэлээр үнэлгээ хийж, дүгнэлт өгч болно³. Үүнд:

1. Охин ба хараат компаниудыг хариуцлагын төвөөр ангилах нь.

Группын бүрэлдэхүүнд байгаа охин компани тус бүрийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд нь гадаад орчин, групп дэх компани тус бүрийн байр суурь болон харилцааны системээс хамаардаг. Группын бүрэлдэхүүнд үйл ажиллагаа нь явагдаж үр дүнтэй ажилладаг, мөн эсрэгээрээ үр ашиггүй ажилладаг охин компаниуд ч байдаг. Иймд, охин компаниудыг орлогын төв, ашгийн төв, нормативт зардлын төв, удирдлагын зардлын төв, хөрөнгө оруулалтын төв гэхчилэн хариуцлагын төвүүдээр ангилж, группын хэмжээнд хариуцлагын

² Нямаа, Д., Санхүүгийн нэгтгэсэн тайлагналын онол, арга зүйн зарим асуудал, Улаанбаатар, МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2015

³ Голубев, М.П., Методология созданных эффективных вертикально-интегрированных холдингов, Учебное пособие, 2010

тайлагналын системийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Хариуцлагын төв гэдэгт аж ахуйн нэгжийн тодорхой ажил үүрэг хариуцсан сегмент буюу охин компанийг ойлгож болно.

Охин компанийн үйл ажиллагааны үр дүн, ашигт ажиллагааг олсон ашгийнх нь абсолют дүнгээр үнэлбэл цар хүрээний нөлөөлөл тусгагдаж үнэлгээнд гажуудал үүсдэг. Өөрөөр хэлбэл их хөрөнгө ашигладаг том охин компани их ашигтай ажиллах нь ойлгомжтой. Харин, ашгийн норм буюу ашгийн дундаж хувиар үнэлбэл салбарын нөлөөллөөс болж үнэлгээ буруу тодорхойлогдоно. Хөрөнгийн эргэц хурдантай худалдааны салбар дахь бизнесийн ашгийн норм эргэц удаантай барилгын салбарынхаас ямагт бага байдаг.

Иймээс, үйлдвэрлэлийн өөр өөр салбар дахь хөрөнгө оруулалтын төв (охин компани)-үүдийг өөр хооронд нь зэрэгцүүлэн үйл ажиллагааны үр дүнг нь бодитой үнэлэх боломжит аргууд болох хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь, өгөөжийн нормоос давсан ашиг зэрэг аргуудыг ашиглан охин компаниудын үйл ажиллагааг үнэлэх нь зүйтэй.

2. Охин компаниудын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх нь.

Группын зохион байгуулалттай аж ахуйн нэгжүүдийн хувьд дараах үзүүлэлтийн системийг ашиглан толгой компанийн хяналтанд байгаа охин компаниудын үйл ажиллагааг үнэлж дүгнэж болно⁴.

Хүснэгт 1. Охин компанийн үйл ажиллагааны үр дүнг хэмжих үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Үзүүлэлтийг тооцоолох томъёо	Мэдээллийн эх үүсвэр
1	Ашгийн татвар, хүү болон элэгдлийн өмнөх ашиг	мян.төг	$АТХЭӨА = \text{Татварын өмнөх ашиг} + \text{Төлөх хүү} + \text{Элэгдэл}$	Орлогын дэлгэрэнгүй тайлан, Санхүүгийн байдлын тайлан
2	Цэвэр мөнгөн гүйлгээ	мян.төг	$Цэвэр мөнгөн гүйлгээ = \text{Хүү, татварын өмнөх ашиг (ЕВИТ)} * (1 - \text{T}) + \text{Элэгдэл} - \text{Капиталын зардал} - \Delta \text{Цэвэр эргэлтийн капитал} + \text{Урт хугацаат өр}$	Орлогын дэлгэрэнгүй тайлан, Санхүүгийн байдлын тайлан
3	Цэвэр ашиг	мян.төг	$ЦА = \text{БО} + \text{БусО} - \text{БӨ} + \text{ҮАЗ} + \text{БусЗ}$	Орлогын дэлгэрэнгүй тайлан

⁴ Об утверждении методики расчета целевых показателей эффективности деятельности дочерних обществ ОАО "РЖД". [Http://www.rgd.ru](http://www.rgd.ru)

4	Цэвэр хөрөнгө	мян.төг	Цэвэр хөрөнгө=Нийт хөрөнгө-Нийт өр төлбөр	Санхүүгийн байдлын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан
5	Хөдөлмөрийн бүтээмж	мян.төг/ хүн	Хөдөлмөрийн бүтээмж = (i төрлийн бүтээгдэхүүний үнэ*(1-үнийн өсөлтийн индекс)*) i төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ/ Ажиллагчдын дундаж тоо	Аналитик бүртгэлийн мэдээлэл
6	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	%	Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа=Татварын өмнөх ашиг/Өөрийн хөрөнгийн дундаж дүн	Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан
7	Борлуулалтын ашигт ажиллагааны түвшин	%	Борлуулалтын ашигт ажиллагаа= Нийт ашиг/ Борлуулалтын орлого	Орлогын дэлгэрэнгүй тайлан
8	Гадагш борлуулалтын ашигт ажиллагааны түвшин	%	Гадагш борлуулалтын ашигт ажиллагаа=Гадагш борлуулалтын нийт ашиг/ Гаднын хэрэглэгчдэд борлуулсан борлуулалтын орлого	Орлогын дэлгэрэнгүй тайлан
9	Группын толгой компанийн ашгийн хувь хэмжээний өсөлт	%	Группын толгой компанийн ашгийн хувь хэмжээний өсөлт=(Төлөвлөсөн хугацаан дахь толгой компанийн ашгийн хувь хэмжээ-Тайлант хугацаан дахь толгой компанийн ашгийн хувь хэмжээ) / Тайлант хугацаан дахь толгой компанийн ашгийн хувь хэмжээ	Нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

3. Охин компанийн өнөөгийн байдлыг үнэлэх нь.

Интеграцлагдсан группын бүрэлдэхүүн дэх аж ахуйн нэгж (охин компани)-ийн өнөөгийн байдлыг үнэлэхдээ дараах 4 хүчин зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй ⁵.

⁵ Шубенцева, Л.А, Формирование оптимального состава участников холдинга, Научный журнал: Аудит и финансовый анализ, №1, 2013

- ✓ Үндсэн хөрөнгийн эзэмшилтийн байдлаарх үнэ цэнэ Y_i
- ✓ Группын бүрэлдэхүүн дэх бусад аж ахуйн нэгжүүдтэй холбогдох харилцаа холбоо X_i
- ✓ Компанийн санхүүгийн байдал C_i
- ✓ Охин компанийн толгой компаниасаа хамаарах хамаарлын түвшин буюу өмчийн дүнд толгой компанийн эзлэх хувь хэмжээ Θ_i

Үндсэн хөрөнгийн эзэмшилтийн байдлаарх охин компанийн үнэ цэнэ

Группын хөрөнгийн бүтцэд үйлдвэрлэлийн хүчин чадал, өөрөөр хэлбэл үндсэн хөрөнгө илүү их үнэ цэнэтэй байдаг тул группын бүрэлдэхүүн компаниудад хөрөнгө хэрхэн хуваарилагдсан болон компани тус бүрийн үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртгийн хувь хэмжээг үнэлэх нь зайлшгүй чухал байдаг. Түүнчлэн, охин компанийн үндсэн хөрөнгийн үнэлгээнд группын бүрэлдэхүүн дэх охин компаниудын үндсэн хөрөнгийн цаашид ашиглагдах боломж болон элэгдлийн түвшинг авч үзэх бас шаардлагатай юм.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртгийн харьцангуй үнэлгээ болон түүний элэгдлийн хувь нь охин компанийн үнэ цэнийг үл хөдлөх хөрөнгийн эзэмшилтийн талаас нь тодорхойлж байгаа тул үзүүлэлтүүдийг ач холбогдлын хувьд 0, 1, 2 гэсэн тодорхой оноогоор үнэлж тооцоололд ашиглаж болно. Үүнд:

- Үндсэн хөрөнгө болон түүний элэгдэл нь их хувь хэмжээтэй, (30%-иас их) аж ахуйн нэгжид 2 оноо,
- Үндсэн хөрөнгө нь дунд зэргийн хувь хэмжээтэй, их биш элэгдэлтэй аж ахуйн нэгжид 1 оноо,
- Үндсэн хөрөнгө нь маш их элэгдэлтэй аж ахуйн нэгжид 0 гэсэн оноо өгнө.

Группын бүрэлдэхүүн дэх бусад аж ахуйн нэгжүүдтэй холбогдох харилцаа холбоо

Толгой компаниас охин компаниудын үйл ажиллагааг үнэлж дүгнэхэд компаниудын аж ахуйн интеграцчлалын түвшинг харгалзан үзэх нь зүйтэй. Компанийн аж ахуйн интеграцчлалын түвшин нь группын бүрэлдэхүүн дэх тухайн охин компани бусад охин компаниудаасаа хэрхэн хамаарах хамаарлын түвшинг харуулах ба аль компани нь илүү чухал байна гэдгийг харуулдаг. Аж ахуйн интеграцчлалын түвшин нь компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт болон түүхий эд материалын нийлүүлэлт дэх хувь оролцоог илэрхийлэх ба түүнийг үйлдвэрлэлийн хэмжээ, бэлтгэн нийлүүлэгчдийн хувь оролцоо, нөөц хэрэглэгчдийн хувь оролцооны харьцангуй үнэлгээнд үндэслэн тодорхойлно.

Охин компани тус бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээний харьцангуй үнэлгээ нь группын хэмжээгээрх үйлдвэрлэлийн хэмжээнд эзлэх хувиар тодорхойлогдоно.

$$q_i = Q_i / \sum Q_i$$

Q_i – Охин компани тус бүрийн бүтээгдэхүүн үйлчилгээ

$\sum Q_i$ – Группын дүн

Үнэлгээнд өмнөхтэй адилаар 0-ээс 2 гэсэн оноог ашиглан,

- Аж ахуйн интеграцчлалын түвшин доогуур аж ахуйн нэгжид 0 гэсэн ач холбогдол,
- Интеграцчлалын түвшин дээгүүр аж ахуйн нэгжид 2 гэсэн ач холбогдол өгч болно.

Группын охин компаниудын төлбөрийн чадварын өнөөгийн байдлын үнэлгээ

Группын бүрэлдэхүүн охин компаниудын санхүүгийн байдал C_i -ыг төлбөрийн чадварын өнөөгийн боломжийн коэффициент, нэг зээлдүүлэгчид төлөх өглөгийн харьцуулсан үнэлгээ болон үйлдвэрлэлийн хэмжээний харьцуулсан үнэлгээнд үндэслэн тодорхойлж болно. Төлбөрийн чадварын өнөөгийн боломжийн коэффициент нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах эргэлтийн хөрөнгийн хангамжийн байдал болон эргэлтийн хөрөнгөөрөө богино хугацаат өр төлбөрөө барагдуулах чадварыг харуулах ба үйлдвэрлэлийн нөөц, бэлэн бүтээгдэхүүн, мөнгөн хөрөнгө, авлага, бусад эргэлтийн хөрөнгөнөөс бүрдсэн эргэлтийн хөрөнгө ба богино хугацаат өр төлбөр (банкны богино хугацаат зээл, богино хугацаат өр төлбөр, байгууллагад төлөх өглөг) - ийн харьцаагаар тодорхойлогдоно. Аж ахуйн нэгжийн салбарын онцлогоос хамаарахгүйгээр энэхүү коэффициентын нормативт утга ерөнхийдөө 2-той тэнцүү байдаг.

- Төлбөрийн чадварын өнөөгийн боломжийн коэффициент 1,5 хүртэл байвал ач холбогдлыг 0,
- 1,5-2,5 байвал ач холбогдлыг 1,
- Төлбөрийн чадварын өнөөгийн боломжийн коэффициент 2,5-аас их байвал ач холбогдлыг 2 гэж үзэж болно..

Төлбөрийн чадварын өнөөгийн боломжийн коэффициент их утгатай гарвал эргэлтийн хөрөнгийн ашиглалт муу байгааг харуулах хэдий ч ийм компанийн санхүүгийн өнөөгийн байдлыг тогтвортой гэж үздэг.

Охин компанийн толгой компаниасаа хамаарах хамаарлын түвшин

Группын бүрэлдэхүүн дэх охин компаниудын толгой компаниасаа хамаарах хамаарлын түвшин Θ_i -г үйлдвэрлэлийн хэмжээний харьцангуй үнэлгээ, өмчийн дүн дэх толгой компанийн хувь оролцоо болон бүтээгдэхүүн борлуулалтын тоо хэмжээний харьцангуй үнэлгээнд үндэслэн тодорхойлж болно.

Судалгааны хэсэг. “XXX” групп компанийн охин компаниудын оноогийн байдлын үнэлгээ, тооцоолол, үр дүн

Хүснэгт 2. “XXX” групп компанийн охин компаниудыг үндсэн хөрөнгөөр эрэмбэлсэн байдал

Компанийн нэр	Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртөг /%/	Үндсэн хөрөнгийн элэгдэл /%/	Үнэлгээ /оноо/
Охин компани 1	7,4	10	2
Охин компани 2	4,0	9	2
Охин компани 3	16,3	18	1
Охин компани 4	21,1	18,4	1
Охин компани 5	17,2	10,6	2
Охин компани 6	40	41,0	0

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 3. Охин компаниудыг группын бүрэлдэхүүн аж ахуйн нэгжүүдтэй холбогдох харилцаа холбоогоор эрэмбэлсэн байдал

Компанийн нэр	Группын бэлтгэн нийлүүлэгчдийн хувь оролцоо /%/	Группын нөөц хэрэглэгчдийн хувь оролцоо / %/
Охин компани 1	10,0	100
Охин компани 2	37,4	0
Охин компани 3	90,0	21
Охин компани 4	23,0	0
Охин компани 5	6,0	0
Охин компани 6	7,82	0

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 4. Охин компаниудыг санхүүгийн байдлаар эрэмбэлсэн байдал

Компанийн нэр	Нэг зээлдүүлэгчид төлөх өглөгийн харьцангуй үнэлгээ /%/	Төлбөрийн чадварын өнөөгийн боломжийн коэффициент /%/
Охин компани 1	3,7	2,82
Охин компани 2	43,0	0,877
Охин компани 3	7,9	0,89
Охин компани 4	0,7	4,0
Охин компани 5	30,0	1,0
Охин компани 6	23,5	2,0

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 5. Охин компаниудыг толгой компаниасаа хамаарах хамаарлаар эрэмбэлсэн байдал

Компанийн нэр	Өмчийн дүн дэх толгой компанийн эзэмшлийн хувь /%/	Борлуулалтын хэмжээний харьцангуй үнэлгээ /%/
Охин компани 1	100	12,9
Охин компани 2	51	3,9
Охин компани 3	100	8,8
Охин компани 4	100	32,4
Охин компани 5	51	1,2
Охин компани 6	30	40,8

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Группын бүрэлдэхүүн дэх охин компаниудын өнөөгийн байдал

Охин компаниудын өнөөгийн байдлыг дээрх бүрэлдэхүүн үзүүлэлт тус бүрийн ач холбогдолд үндэслэн экспертийн аргаар олж авсан K_z , K_f , K_D , K_I гэсэн хувийн жингийн коэффициентуудыг ашиглан тооцоолж харуулья.

Хувийн жингийн коэффициентуудын утгыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. Үзүүлэлтүүдийн ач холбогдол

Интеграл үзүүлэлт	Үзүүлэлтүүд	Хувийн жингийн коэффициентууд	
Аж ахуйн нэгжийн өнөөгийн байдал ΘB_i	Үндсэн хөрөнгө Y_i	K_y	0,30
	Санхүүгийн байдал C_i	K_c	0,15
	Өмч дэх хувь оролцоо Θ_i	K_Θ	0,20
	Бусад аж ахуйн нэгжүүдтэй холбогдох харилцаа холбоо X_i	K_x	0,35

Группын бүрэлдэхүүн дэх аж ахуйн нэгжүүдийн өнөөгийн байдлыг тодорхойлох интеграл үзүүлэлтийг томъёолон харуулбал дараах байдалтай болно.

$$\Theta B_i = K_y Y_i + K_c C_i + K_\Theta \Theta_i + K_x X_i$$

Байр эзлүүлэх арга⁶ ашиглан “ХХХ” группын охин компаниудын өнөөгийн байдлын нэгдсэн үнэлгээг эрэмбэлэн харуулбал:

“Өнөөгийн байдал” интеграл үзүүлэлтийн нэгдсэн үнэлгээ

Компанийн нэр	Үндсэн хөрөнгө		Санхүүгийн байдал		Өмч дэх хувь оролцоо		Бусад компанигай холбогдох харилцаа		Дүн	Байр
Хувийн жин	0,30		0,15		0,20		0,35		1	
Охин компани 1	1	0,30	2	0,30	2	0,40	2	0,70	1,70	1
Охин компани 2	1	0,30	0	0,00	1	0,20	0	0,00	0,50	6
Охин компани 3	2	0,60	0	0,00	2	0,40	1	0,35	1,35	2
Охин компани 4	2	0,60	2	0,30	2	0,40	0	0,00	1,30	3
Охин компани 5	2	0,60	0	0,00	1	0,20	0	0,00	0,80	4
Охин компани 6	2	0,60	1	0,15	0	0,00	0	0,00	0,75	5

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дүгнэлт

Бизнесийн үйл ажиллагаа өргөжин тэлж групп компаниуд үүсэх тусам дээд түвшний удирдлагын шийдвэр гаргалт, группын төлөвлөлт, зохион байгуулалт, хяналтын үйл ажиллагааны цар хүрээ нэмэгддэг тул үүрэг хариуцлагыг зөв хуваарилан, төвлөрсөн болон төвлөрсөн бус хяналтыг хамтад нь хэрэгжүүлэх зайлгүй шаардлагатай юм.

Группын хэмжээгээрх нэгтгэсэн санхүүгийн тайланд ерөнхий шинжилгээ /хөрөнгө, өр төлбөр, өмч, орлого, зардлын хэлбэлзэл өөрчлөлтийн болон бүтэц бүрэлдэхүүний, хөрөнгийн хөрвөх чадварын болон төлбөрийн чадварын, санхүүгийн тогтвортой байдлын, хөрөнгийн ашиглалтын болон оруулсан хөрөнгийн өгөөжийн шинжилгээ/ хийж дүгнэлт өгөхөөс гадна нэгтгэсэн санхүүгийн тайлангаарх үр дүнгийн үзүүлэлтэд охин компани тус бүрийн санхүүгийн үзүүлэлтүүдийн үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, улмаар охин

⁶ Савицкая, Г. В. Методика комплексного анализа хозяйственной деятельности, Москва, 2006

компани тус бүрийн үйл ажиллагаа, үр дүнгийн өнөөгийн байдлыг үнэлж, эрэмбэлэх нь группын толгой болон охин компанийн харилцан хамаарлыг илүү нарийн тодорхойлж, бизнесийг группын түвшинд буюу бүхэлд нь үр ашигтай удирдахад чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Иймд, групп компанийн бүрэлдэхүүний охин компаниудын өнөөгийн байдлыг үнэлэх дээрх интеграл үзүүлэлтийг группын бүтэцтэй аж ахуйн нэгжүүд бүрэлдэхүүн компаниудын оновчтой бүтцээ бий болгох сонголтондоо хэрэглэж болох юм.

Илүү их синергетик үр өгөөжтэй байхын тулд үндсэн бизнест нэмэр болохуйц компаниудыг группын бүтцэд оруулж, үндсэн бизнесийн үйл ажиллагаанд оролцоо багатай буюу өнөөгийн байдал нь тааруу болон үр өгөөж муутай компаниудыг группын бүтцээс гаргах бодлого баримтлах нь зүйтэй.

Ашигласан материал

- [1] Шубенцева, Л.А, Формирование оптимального состава участников холдинга, Научный журнал: Аудит и финансовый анализ, №1, 2013
- [2] Нямаа , Д, Санхүүгийн нэгтгэсэн тайлагналын онол, арга зүйн зарим асуудал, Улаанбаатар, МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2015
- [3] Голубев, М.П, Методология созданных эффективных вертикально-интегрированных холдингов, Учебное пособие, 2010
- [4] Савицкая, Г.В, Методика комплексного анализа хозяйственной деятельности, Москва, 2006
- [5] Об утверждении методики расчета целовых показателей эффективности деятельности дочерних обществ ОАО “РЖД”. [Http://www.rgd.ru](http://www.rgd.ru)
- [6] ХХХ групп компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлан , охин компаниудын санхүүгийн тусдаа тайлан, 2017